



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй  
тэмцэх зарим арга хэмжээний тухай”

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний анхны шинж тэмдэг илэрч, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн шинжилгээний дүгнэлтээр “О” хэвшлийн шүлхий өвчин болох нь тогтоогдсон.

Үүнээс хойш уг өвчний гаралт, тархалт нэмэгдэж, Сүхбаатар аймгийн 9, Дорнод аймгийн 3, Хэнтий аймгийн 5, Дорнговь аймгийн 3, Төв аймгийн 1, Дундговь аймгийн 3 сум буюу нийт 7 аймгийн 24 сум, нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт шүлхий өвчин оношлогдон, 485 малчин өрхийн 4525 толгой үхэр, 910 толгой хонь, 602 толгой ямаа, нийт 6037 толгой мал өвчилснөөс 5147 толгой малыг зориудаар устгалд хамруулсан байна.

Өнөөдрийн байдлаар Хэнтий аймгийн Хэрлэн, Төв аймгийн Сэргэлэн, Дундговь аймгийн Гурван сайхан, Өлзийт, Сайнцагаан, Дорнод аймгийн Цагаан-Овоо, Сүхбаатар аймгийн Асгат, Мөнххаан сум, нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг зэрэг нийт 6 аймаг, нийслэлийн 9 сум, дүүрэгт хорио цээрийн дэглэм үргэлжилж байна.

Уг өвчний гаралт, тархалт буурахгүй байгаа гол шалтгаан нь малчид малаа тарилгад бүрэн хамруулахгүй байгаа, орон нутаг дахь хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт хангалтгүй, ихэнх аймагт гантай буюу гандуу байгаа учир отор нүүдэл, малын хөдөлгөөн их хийгдэж байгаатай шууд холбоотой гэж мэргэжлийн байгууллагаас дүгнэсэн.

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний гаралт, тархалтыг бүрэн хяналтанд авах, голомтыг устгах, өвчин гарсан бус нутагт тогтоосон хорио цээрийн дэглэмийг эрчимжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2017 онд шүлхий өвчин бүртгэгдсэн болон шүлхий өвчний улмаас хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаа зарим аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт дараахи АЛБАН ДААЛГАВРЫГ хүргүүлж байна.

Нэг. Дорнод, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий, Төв аймгийн

Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

- 1.1.Хорио цээрийн дэглэм тогтоосон аймаг, сумдад хүн, мал, амьтны хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний тээвэрлэлтийг хязгаарлах, хэв журам сахиулах, олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байх, мал сүргийг дархлаажуулах ажлыг богино хугацаанд гүйцэтгэхэд орон нутгийн иргэд, мэргэжлийн албадын үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах;
- 1.2.Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн автозамын уулзварт (Дорнод - Сүхбаатар аймгийн зам, Хэнтий аймгийн төв зам нийлдэг хэсэг) З аймгийн мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл бүхий хяналтын цэг байгуулах, халдвартгүйжүүлэлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, зардлыг орон нутгийн төсвийн хүрээнд шийдвэрлэх, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг хүлээн зөвшөөрөгдсөн маягтын дагуу олгох.
- 1.3.Шүлхий өвчин бүртгэгдсэн аймгийн нутаг дэвсгэрээс бусад аймаг, нийслэл рүү, эрүүл бүсээс шүлхий өвчин бүртгэгдсэн аймаг руу чиглэсэн малын шилжилт хөдөлгөөнийг 2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл бүрэн зогсоох;
- 1.4.Сүхбаатар, Дорнод, Дорноговь аймгуудын байнгын ажиллагаатай хилийн боомт дахь мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөлийг сайжруулах, тус газарт халдвартгүйжүүлэлтийн камер байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах;
- 1.5.Шүлхий өвчний хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаа болон эрсдэл хадгалагдаар байгаа аймгуудын нэн шаардлагатай мэргэжлийн албан хаагчдын ээлжийн амралт, гадаад, дотоод томилолтыг түр хугацаагаар түдгэлзүүлэх;
- 1.6. Дээрх аймгуудад нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баяр, уул овооны тахилга, аймаг, сумдын хурдан морины уралдаан, малын үзэсгэлэн болон дуудлага худалдаа гэх мэт олон нийтийг хамарсан арга хэмжээг 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл зохион байгуулахыг хориглох;
- 1.7.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд шүлхий өвчний идэвхгүй тандалтын арга хэмжээг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо, малчид, мал бүхий иргэдийн дэмжлэгтэйгээр 2017 оны 12 дугаар сарын 15-ныг хүртэл сайтар зохион байгуулах, таниулга сурталчилгааг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, малчдад хүргэх, малын эмч нарыг чадавхижуулах;

- 1.8. Шүлхий өвчний байгалийн халдварыг илрүүлэх идэвхгүй тандалтын мэдээлэл болон өвчний сэжигтэй тохиолдол бүрт оношийг баталгаажуулах, холбогдох байгууллагад мэдээллийг дамжуулах;
- 1.9. Халдварын эх үүсвэрийг устгах, эрсдэлийг бууруулж, халдварын тархалтыг хязгаарлах, бүрэн хяналтанд авахад чиглэсэн арга хэмжээг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, заавар, журмын хүрээнд орон нутгийн мэргэжлийн байгууллагуудад бүх талын дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;
- 1.10. Орон нутгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, харьяа салбар нэгждээ гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх, бэлэн байдлыг дээшлүүлэх;
- 1.11. Хорио цээрийн дэглэм сахиулах хугацаанд Гамшгаас хамгаалах тухай болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээд, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

Хоёр. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүүд:

- 2.1. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод ажиллаж байгаа мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар малын шилжилт хөдөлгөөн, малын эрүүл мэнд - гарал үүслийн гэрчилгээний заалт нэг бүрт хяналт тавих;
- 2.2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлах вакцинжуулалтад хичнээн толгой мал хамрагдсан, вакцины чанар, үр дүн, өвчний голомт бүхий бүс нутгийг хамруулсан эсэх, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шалгалт, соён гэгээрүүлэх ажлын үр дүнгийн талаар мэдээлэл ирүүлэх;
- 2.3. Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан бүс нутагт тогтоосон хорио цээрийн дэглэмийг чанд сахиулах, хорио цээрийн дэглэм зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжүүдэд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулж ажиллахыг тус тус даалгасугай.

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Улсын онцгой комиссын Ажлын албанад 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг Дорнод, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий, Төв аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга наарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

УХАД168

